



БАТЛАВ, "ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Ж.Байгалмаа* Ж.БАЙГАЛМАА

Огноо: 2019 оны 11 дүгээр сарын 11

**СҮЛЖЭЭНИЙ ТЕХНИК, ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Гэрээнийдугаар: **ҮЦТХТ-201907002**

2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Сүлжээний техник хэрэгсэл** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019** оны **11** дүгээр сарын **19**-ны өдрийн **10** цаг **00** минутаас өмнө **Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо Самбуугийн гудамж 16/1 тоот 101 тоот** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019** оны **11** дүгээр сарын **19**-ны өдрийн **11** цаг **00** минутанд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх.Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Самбуугийн гудамж 16/1 тоот
Утас:70114424, 88039221**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨЭЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨЭЗ 1.1	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх.</p> <p>Сүүлийн 1 жил гэрээгээр тендерт санал болгож буй болон түүнтэй дүйцхүйц бараа нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх.</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх. 2. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлэх. 3. Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтын цахим тодорхойлолтыг хавсаргах. 4. Үйлдвэрлэгчийн олгосон сертификатыг хавсаргах. 5. Сүүлийн 1 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа маргааны талаарх шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа 6. Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч, цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна. 7. Цахим тендер шалгаруулалтын зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө. 8. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.
ТӨЭЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо Самбуугийн гудамж 16/1 тоот, 2 давхарт хурлын заал 2019 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 10 цаг 00 минут</p>
ТӨЭЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо Самбуугийн гудамж 16/1 тоот, 2 давхарт хурлын заал 2019 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 11 цаг 00 минут</p>
ТӨЭЗ 3.1	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: 3.1-д Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ. 2. Барааны жагсаалт болон бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. 3. Сүүлийн 1 жилийн 2018 онд тендерт санал болгож буй үнийн дүнтэй ижил төстэй барааг нийлүүлсэн байх. /Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар/ 4. Нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталоги ирүүлнэ. 5. Харьяа татварын хэлтэс, харилцагч банкнаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдэлийг тендерийн баримт бичигт хавсаргаж ирүүлнэ. 6. Тендерт оролцогч нь тендерийн материалын хуудас бүрийг дугаарлан баталгаажуулж ирүүлнэ. 7. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. 8. Тоног төхөөрөмжийн баталгааны хугацаа 1 жил байна. <p>Баримт бичгүүд нь Монгол хэлнээс бусад хэл дээр байгаа тохиолдолд</p>

	<p>баталгаат орчуулгын товчоогоор орчуулга хийлгэн тухай бүрт хавсарган ирүүлнэ.</p> <p>Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 4.1	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.
ТӨӨЗ 5.1	Барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт: Шаардлагатай.
ТӨӨЗ 6.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
ТӨӨЗ 7.1	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь CIF үнэ байна. Энэ үнэнд даатгал, татвар болон эцсийн цэг хүртлэх бусад бүх зардлууд багтсан байна.
ТӨӨЗ 7.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 1 багц- Сүлжээний техник хэрэгсэл

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны тодорхойлолт:

Медиа конвертер 1 ширхэг /хос/:

Дамжуулалтын хурд: 10/100/1000Mbps, Single Mode

Дамжуулалтын зай: 20км

Толгойны төрөл: SC

Медиа конвертер модуль 1 ширхэг /хос/:

1.25 Gbps нэвтрүүлэх чадамжтай

Single Mode up to 20km

Свич /24 порт/ 6 ширхэг:

Энгийн

24*10/100/1000Mbps

Раканд суурилуулах боломжтой

Свич /8 порт/ 3 ширхэг:

Энгийн

8*10/100/1000Mbps

Тог баригч 12 ширхэг:

Оффисын хэрэглээнд зориулагдсан

Дуу чимээ бага

1000-1500 VA

Хард диск 2 ширхэг:

Зөөврийн зориулалттай

Багтаамж 2TB ба түүнээс дээш

Хөрвүүлэгч залгуур 5 ширхэг:

Display Port to VGA

- 1. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл *[Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.]* гэж бичнэ
- 2. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]

Бараа хүргэх газар: *Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо Самбуугийн гудамж 16/1 тоот.*

3. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	Медиа конвертер	1	ширхэг	ҮЦТХТ ХХК байр	2019.11.30	2019.12.15	
2	Медиа конвертер модуль	1	ширхэг	ҮЦТХТ ХХК байр	2019.11.30	2019.12.15	
3	Свич /24 порт/	6	ширхэг	ҮЦТХТ ХХК байр	2019.11.30	2019.12.15	
4	Свич /8 порт/	3	ширхэг	ҮЦТХТ ХХК байр	2019.11.30	2019.12.15	
5	Тог баригч	12	ширхэг	ҮЦТХТ ХХК байр	2019.11.30	2019.12.15	
6	Хард диск	2	ширхэг	ҮЦТХТ ХХК байр	2019.11.30	2019.12.15	
7	Хөрвүүлэгч залгуур	5	ширхэг	ҮЦТХТ ХХК байр	2019.11.30	2019.12.15	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1. Бараа агуулхад ирж хүлээнт авахдаа техникийн тодорхойлолтын нөхцөл хангаж буй эсэх, бүрэн бүтэн байдал зэргийг шалган хүүлэн авч, хүлээн авсан акт үйлдэнэ.

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 5.1. Бараа нийлүүлэгч тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 3 жил байна..

4. Төлбөр (ГЕН – 7)
 - 7.1. Урьдчилгаа төлбөр төлөхгүй.
 - 7.2. Захиалагч төлбөрийг бараа хүлээн авч, гэрээ дүгнэж, нэхэмжлэл хүлээн авсанаас хойш 7 хоногт төлбөрийг хийнэ. Гэрээний үнийн дүнгийн 5 хувийг засварын баталгаа болгон суутган авч, гэрээ байгуулсанаас хойш 1 жилийн дараа нийлүүлэгчдэд олгоно.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
 - 9.1. Алданги оногдуулах хувь: **0.5 хувь**
Алдангийн нийт дүн: **5.0 хувиас хэтрэхгүй байна.**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____-наас _____ оны ____ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]